

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гэгээн сумади сургууль цэцэрлэгийн, цоцолборын
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/006/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот

2025 оны 02 дугаар сарын
17-ны өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор Н.Батчимэг
Утас 91113253 Цахим хаяг : batchimegn@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Баян ташаагийн эх аудит
ХХК
Захирал Т.Хоролсүрэн
Утас: 99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
АТБӨЯХ	Авто тээврийн болон өөрөө явах хэрэгсэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement. bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/71

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэгээн сумади сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2024 онд 3,176,754,2 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 3,076,299,4 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст харилцах дансанд 97,308,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

5020344

d:\2025 он\бичиг хэрэг\тоот\2. а4-албан тоот.docx

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт 77 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 95,0 хувьтай тайлагнасныг 92,6 хувьтай дээд шатны байгууллагаас дүгнэсэн байна.

Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА ТЭВГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан			/төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	126,415,453.76	197,172,273.98
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	65,875,431.99	97,308,761.96
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	65,875,431.99	97,308,761.96
3121	Төгрөг	65,875,431.99	97,308,761.96
31211	Төрийн сангийн харилцах	65,875,431.99	97,308,761.96
33	АВЛАГА	373,795.76	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	373,795.76	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	60,166,226.01	99,863,512.02
351	Түүхий эд материал	26,005,310.00	32,709,404.02
35110	Тусгай зориулалттай материал	25,835,400.00	32,180,864.02
35130	Эм боох материал	169,910.00	528,540.00
354	Хангамжийн материал	34,160,916.01	67,154,108.00
35410	Бичиг хэргийн материал	3,128,720.00	2,860,610.00
35420	Аж ахуйн материал	15,255,198.00	15,926,900.00
35470	Бусад хангамжийн материал	15,776,998.00	48,366,598.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,747,962,518.75	6,904,713,984.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,747,962,518.75	6,904,713,984.26
392	Биет хөрөнгө	6,512,970,202.07	6,669,721,667.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,156,808,923.00	6,156,808,923.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-29,745,354.14	-132,358,836.26
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,000,000.00	35,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-4,250,000.00	-8,249,999.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	211,656,760.00	407,552,360.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-54,971,597.47	-108,327,884.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	205,984,222.37	352,609,555.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	-35,348,448.35	-58,351,127.62
39214	Бусад үндсэн хөрөнгө	27,970,200.00	27,970,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-134,503.34	-2,931,523.34
393	Биет бус хөрөнгө	234,992,316.68	234,992,316.68
39301	Програм хангамж	3,750,000.00	3,750,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	234,311,000.00	234,311,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-3,068,683.32	-3,068,683.32
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,874,377,972.51	7,101,886,258.24
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,950,874.99	68,854,292.75
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,950,874.99	68,854,292.75
413	Өглөг	7,950,874.99	68,854,292.75
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	7,950,874.99	00.00
4136	Бусад өглөг	00.00	68,854,292.75
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	68,854,292.75
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,866,427,097.52	7,033,031,965.49
51	Засгийн газрын хувь оролцоо	6,866,427,097.52	7,033,031,965.49
512	Хуримтлагдсан үр дүн	6,866,427,097.52	7,033,031,965.49
51210	Өмнөх үеийн үр дүн	6,866,427,097.52	6,866,427,097.52
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	166,604,867.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,874,377,972.51	7,101,886,258.24

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,449,268,997.20	3,385,908,397.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,342,620,997.20	275,029,397.62
120	Нийтлэг татварын бус орлого	6,342,620,997.20	275,029,397.62
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,820,000.00	00.00
120004	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,820,000.00	00.00
2	2		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,106,648,000.00	3,110,879,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,647,697,900.00	2,559,916,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,647,697,900.00	2,559,916,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	458,950,100.00	550,962,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	458,950,100.00	550,962,900.00
2	2		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,108,806,859.23	3,219,303,529.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,032,040,759.23	3,120,094,996.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,180,648,482.98	1,912,580,999.71
210101	Үндсэн цалин	858,080,041.15	1,816,631,042.71
210102	Нэмэгдэл	259,447,880.25	95,949,957.00
210104	Урамшуулал	63,120,561.58	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	144,981,722.13	239,182,078.08
210201	Тэтгэврийн даатгал	99,517,501.11	164,688,896.76
210202	Тэтгэмжийн даатгал	10,729,335.93	17,171,200.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,320,285.17	9,025,945.30
210204	Ажилгүйдлийн даатгал	2,310,724.88	10,101,936.08
210205	Эрүүл мэндийн даатгал	23,103,875.04	38,194,099.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	464,744,382.71	516,384,791.38
210301	Гэрэл, цахилгаан	31,781,510.71	86,557,823.38
210302	Түлш, халаалт	381,141,812.00	377,109,138.00
210303	Цэвэр, бохир ус	51,821,060.00	52,717,830.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,352,170.09	67,012,559.01
210401	Бичиг хэрэг	10,476,858.00	23,643,210.00
210402	Тээвэр, шатахуун	39,613,668.69	32,294,751.01
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,167,399.40	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,094,244.00	11,074,598.00
2105	Нормативт зардал	86,717,270.00	126,872,720.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	266,370.00	832,920.00
210502	Хоол, хүнс	86,450,900.00	126,039,800.00

Гэгээн сумади сургууль цэцэрлэгийн цогцолборын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,723,302.42	16,547,075.75
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,723,302.42	16,547,075.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,873,428.90	218,033,772.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,764,250.00	32,264,304.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	85,109,178.90	185,769,468.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,766,100.00	99,208,533.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	76,766,100.00	96,062,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,001,500.00	66,453,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,764,600.00	29,609,300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	6,340,462,137.97	166,604,867.97
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	6,340,462,137.97	166,604,867.97

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,111,604,300.00	3,110,879,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,956,300.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,956,300.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,956,300.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,136,300.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,820,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,106,648,000.00	3,110,879,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,647,697,900.00	2,559,916,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,647,697,900.00	2,559,916,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	458,950,100.00	550,962,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	458,950,100.00	550,962,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,063,882,129.38	3,079,445,670.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,063,882,129.38	3,079,445,670.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,987,815,129.38	2,980,237,136.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,180,648,492.98	1,912,580,999.71
210101	Үндсэн цалин	813,740,128.99	1,287,564,882.22
210102	Нэмэгдэл	303,787,802.41	524,636,217.49
210104	Урамшуулал	63,120,561.58	100,379,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,355,507.89	238,808,282.32
210201	Тэтгэврийн даатгал	98,976,866.40	161,631,577.96
210202	Тэтгэмжийн даатгал	11,643,766.40	19,394,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,315,493.14	9,697,000.00

Гэгээн сумади сургууль цэцэрлэгийн цогцолборын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	2,310,724.88	9,697,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,108,657.07	38,388,504.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	458,950,100.00	524,335,666.37
210301	Гэрэл, цахилгаан	29,883,288.00	36,739,904.37
210302	Түлш, халаалт	381,141,812.00	430,981,872.00
210303	Цэвэр, бохир ус	47,925,000.00	56,613,890.00
2105	Нормативт зардал	87,150,000.00	126,039,800.00
210502	Хоол, хүнс	87,150,000.00	126,039,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,973,399.82	33,308,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,136,300.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,837,099.82	33,308,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,737,628.69	121,682,588.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,982,028.69	108,016,688.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,755,600.00	13,665,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,067,000.00	99,208,533.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	76,067,000.00	96,062,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,302,400.00	66,453,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,764,600.00	29,609,300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	47,722,170.62	31,433,329.97
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	47,722,170.62	31,433,329.97
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,153,261.37	65,875,431.99
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	65,875,431.99	97,308,761.96



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			528,890,398.74	528,890,398.74
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			528,890,398.74	528,890,398.74
C07	Тайлант үеийн үр дүн			6,340,462,137.97	6,340,462,137.97
C08	2022оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			6,866,427,097.52	6,866,427,097.52
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			6,866,427,097.52	6,866,427,097.52
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			6,866,427,097.52	6,866,427,097.52
D08	Тайлант үеийн үр дүн			166,604,867.97	166,604,867.97
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			7,033,031,965.49	7,033,031,965.49

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,176,754,200.00	3,079,445,670.03	97,308,529.97	96.9
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3,176,754,200.00	3,079,445,670.03	97,308,529.97	96.9
210	Бараа, үйлчилгээний зардал	3,077,754,800.00	2,980,237,136.40	97,517,663.60	96.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,976,892,000.00	1,912,580,999.71	64,311,000.29	96.7
210101	Үндсэн цалин	1,314,604,500.00	1,287,564,882.22	27,039,617.78	97.9
210102	Нэмэгдэл	560,141,100.00	524,636,217.49	35,504,882.51	93.6
210104	Урамшуулал	102,146,400.00	100,379,900.00	1,766,500.00	98.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	247,111,600.00	238,808,282.32	8,303,317.68	96.6
210201	Тэтгэврийн даатгал	168,035,900.00	161,631,577.96	6,404,322.04	96.1
210202	Тэтгэмжийн даатгал	19,769,000.00	19,394,200.00	374,800.00	98.1
210203	ҮОМШӨ ний даатгал	9,884,400.00	9,697,000.00	187,400.00	98.1
210204	Ажилгүйдлийн даатгал	9,884,400.00	9,697,000.00	187,400.00	98.1
210205	Эрүүл мэндийн даатгал	39,537,900.00	38,388,504.36	1,149,395.64	97.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	527,481,900.00	524,335,666.37	3,146,233.63	99.4
210301	Гэрэл цахилгаан	39,500,000.00	36,739,904.37	2,760,095.63	93.0
210302	Түлш, халаалт	430,981,900.00	430,981,872.00	28.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	57,000,000.00	56,613,890.00	386,110.00	99.3
2105	Норматив зардал	146,457,200.00	126,039,800.00	20,417,400.00	86.1
210502	Хоол, хүнс	146,457,200.00	126,039,800.00	20,417,400.00	86.1
2106	Эд хогшил худалдан авах	23,481,000.00	23,481,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	23,481,000.00	23,481,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	33,308,800.00	33,308,800.00	-	100.0
210806	Мэдээллийн технологийн зардал	33,308,800.00	33,308,800.00	-	100.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	123,022,300.00	121,682,588.00	1,339,712.00	98.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	109,356,400.00	108,016,688.00	1,339,712.00	98.8



Гэгээн сумади сургууль цэцэрлэгийн цогцолборын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,665,900.00	13,665,900.00	-	100.0
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,999,400.00	99,208,533.63	(209,133.63)	100.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	98,999,400.00	96,062,300.00	2,937,100.00	97.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	69,390,100.00	66,453,000.00	2,937,100.00	95.8
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	29,609,300.00	29,609,300.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,176,754,200.00	3,110,879,000.00	65,875,200.00	97.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			-	100.0
		2,558,932,100.00	2,558,932,100.00		
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,558,932,100.00	2,558,932,100.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	550,962,900.00	550,962,900.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	550,962,900.00	550,962,900.00	-	100.0
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	66,859,200.00	984,000.00	65,875,200.00	
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	984,000.00	984,000.00		100.0
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	65,875,200.00			
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	65,875,431.99	-65,875,431.99	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	97,308,761.96	-97,308,761.96	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	13.00	13.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	3.00	3.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	9.00	9.00	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолбор нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тодорхойлсон “Суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолбор нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захирлын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар Захиргаа аж ахуй, Сургалтын алба бүтэц зохион байгуулалттай 86 орон тоотой, 630 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай” 25 дугаар тогтоолын хавсралт” Боловсролын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”
- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр журам батлах тухай” 39 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 84, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд Боловсролын ерөнхий газар болон аймгийн Боловсролын газрын хамтарсан хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын шалгалт хийгдэж Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборт 13,825.7 мянган төгрөгийн 3 акт тогтоож, 45,788.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-1 ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 227,508.3 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	65,875.4	97,308.8	31,433.4
Бараа материал	60,166.2	99,863.5	39,697.3
Үндсэн хөрөнгө	6,875,481.1	7,218,002.1	342,521.0
Хуримтлагдсан элэгдэл	-127,518.6	-313,288.1	-185769.5
Нийт хөрөнгө	6,874,378.0	7,101,886.3	227,508.3
Өр төлбөр	7,950.9	68,854.3	60,903.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,866,427.1	7,033,032.0	166,604.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,874,378.0	7,101,886.3	227,508.3

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Гэгээн сумади сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын 2024 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Тайлант онд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 97,308.9 мянган төгрөг болж өмнөх оноос 31,433.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гүйцэтгэлээр санхүүжиж хэмнэгдсэн зардлын дүн голлон нөлөөлсөн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 279,990.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 26,545.5 мянган төгрөгийн бараа үнэ төлбөргүй орлого авч, нийт 266,838.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулж бараа материалын үлдэгдэл 39,697.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө тайлант онд Боловсролын ерөнхий газраас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 237,484.0 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 105,037.0 мянган төгрөг нийт 342,521.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант оны эцэст өглөг дансны үлдэгдэл 60,903.4 мянган төгрөгөөр өссөн нь ерөнхий гэрээгээр худалдаж авсан дөрвөн жилийн хугацаанд төлбөрийг барагдуулах бараа материалын өглөг голлон нөлөөлсөн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 166,604.9 мянган төгрөгөөр нэмэгдэж 7,101,886.3 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,632,935.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг 1,632,935.4 мянган төгрөгөөр баталжээ. Төсвийн тодотголоор 926,980.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,559,916.0 мянган төгрөг болгон баталсан нь багш ажилчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн хүрээнд 17 арга хэмжээг санхүүжүүлэх зардлын эх үүсвэрийг улсын төсвөөс 2,559,916.0 орон нутгийн төсвөөс 550,962.9 мянган төгрөгөөр тус тус бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,559,916.0 мянган төгрөг, үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогоос 65,875.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, улсын төсвөөс цалин, нийгмийн даатгалын зардлуудад 2,151,389.3 мянган төгрөг, нормативд зардалд 126,039.8 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийн зардалд 96,062.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 121,682.5 мянган төгрөг, мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд 33,308.8 мянган төгрөг нийт 2,528,482.8 мянган төгрөгийг зарцуулж 97,308.5 мянган төгрөг зарцуулагдаагүй харилцах дансанд үлдэгдэлтэй байна. Орон нутгийн төсвөөс 550,962.9 мянган төгрөгийн санхүүжилт авч байр ашиглалтын зардалд 547,816.7 мянган төгрөгийг зарцуулж 3,146.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн улсын төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,997,795.9 мянган төгрөг буюу 87.8 хувь, орон нутгийн төсвийн нийт зардлын гүйцэтгэл 166,171.2 мянган төгрөг буюу 93.4 хувь байгаа нь улсын төсвийн зардлыг хэмнэн дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
71601	Ерөнхий Боловсролын сургалт	3,176,754.2	3,079,445.67	97,308.53	96.9
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,559,916.1	2,531,629.0	94,163.3	98.9
83112	Хөтөлбөр төслийн дотоод урсгал	550,962.0	547,816.67	3,146.23	99.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Баян ташаагийн эх” аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Хандсүрэн гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Т.Хоролсүрэн, хоёр дахь шатны хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг “Баян ташаагийн эх” аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал П.Адьяа, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч А.Дулмаа нар зурж ажиллажээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийн зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 3,278,154.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 32,781.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 22,947.1 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3,177,206.7 мянган төгрөгийн 151 гүйлгээ, зарлагын 597,141.4 мянган төгрөгийн 38 гүйлгээ, хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай “нийцсэн” гэж дүгнэлээ.

4.4.2 Худалдан авах ажиллагааны талаар

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсөл, худалдан авах 215,547.3 мянган төгрөгийг тусгаж баталснаас, гүйцэтгэлээр 192,492.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үдийн цай хөтөлбөр хүнсний материал нээлттэй тендер шалгаруулах журмаар 66,453.0, мянган төгрөг дотуур байрны хоол зардал 126,039.8 мянган төгрөгөөр худалдаж авсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймгийн Төрийн аудитын аудитор С.Цэвээнсүрэн гүйцэтгэж 50,190.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн. Аудитаар өгсөн албан шаардлага төлбөрийн актын хэрэгжилтийг тус байгууллагаас 2024 оны 05 дугаар сарын 30-ны 68 тоот албан бичгээр ирүүлж бүрэн биелүүлж ажиллажээ.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	50,190.0	1	50,190.0	100
Нийт дүн	1	50,190.0	1	50,190.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын урамшууллыг олгохдоо “Өөрчлөлтгүй” гэж дүгнэгдсэн боловч төлбөрийг акт тогтоосон байхад нягтлан бодогч үндсэн цалингийн 3 сартай тэнцэх хэмжээний урамшуулал олгох тушаал гарган олгосон байна.

Иймд дараагийн аудитаар дээрх урамшууллыг хавтгайруулан олгосон эсэх асуудлыг авч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,544.0 мянган төгрөгийн 1 зөрчил¹ илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлэв.

5.1 Албан шаардлага

Боловсролын ерөнхий газар, аймгийн Боловсролын газрын дарын 224 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн 2/2772 тоот албан бичгийг үндэслэн төсвийн шууд захирагчид нэг сарын үндсэн цалинтай тэнцэх балансын шагнал урамшууллыг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн шууд захирагч нарт балансын урамшуулал олгодог байдлыг таслан зогсоох зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сургуулийн захирал П.Адъяад аймгийн БШУГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 2/2772 тоот албан бичгийг үндэслэн нэг сарын үндсэн цалинтай тэнцэх балансын шагнал урамшууллыг олгосон байна.	1	1,544.0			1	1,544.0		
Дүн	1	1,544.0			1	1,544.0		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 195/11423044/БНА-2025/
006/НА-СТН-ТШЗ Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Боловсролын ерөнхий газар, аймгийн Боловсролын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 2/2772 тоот албан бичгийг үндэслэн төсвийн шууд захирагчид нэг сарын үндсэн цалинтай тэнцэх 1,544,000 (Нэг сая таван зуун дөчин дөрвөн мянган) төгрөгийн балансын шагнал урамшууллыг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8.байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй,” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн шууд захирагч нарт балансын урамшуулал олгодог байдлыг таслан зогсоож, зөрчлийг арилгасан талаарх нотлох баримтыг FAS системд оруулж, албан шаардлагын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

6425040503

АУДИТ 2025

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборын захирал П.Адъяа, нягтлан бодогч А.Дулмаа нарт даалгав¹.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН²

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

“БАЯН ТАШААГИЙН ЭХ”
АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Т.ХОРОЛСҮРЭН

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

² Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно